



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/141

Номгон

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар”
дундын стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх
/2023-2026 он/ арга хэмжээний төлөвлөгөөний
хэрэгжилтэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Аймгийн хөгжлийн төлөвлөгөө батлах тухай 17/59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Жендэрийн салбар хороо, Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т тус тус үүрэг болгосугай.

2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зардлыг хавсралтаар баталсугай.

3.Үйл ажиллагаанд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, жендэрийн салбар хорооны орлогч дарга (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624010283

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дугаар сарын
12-ны өдрийн 1111 дүгээр захирамжийн хавсралт



ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР
ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
/2023-2026 ОН/ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Төсөв	Хамтрагч
Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах				
1	Шинээр сонгогдсон ИТХ-ын гишүүдэд чадавхжуулах сургалт зохион байгуулах	4 дүгээр улиралд	2.000.000	Жендэрийн салбар хороо
2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж бодлогын зөвлөмж гаргах	4-5 дугаар сар	2.500.000	Нийгмийн бодлогын хэлтэс
Жендэрийн мэдрэмжтэй төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллага шалгаруулах алдаршуулах				
3	Бүх төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад "Жендэрийн мэдрэмжтэй төрийн алба" уралдаан зарлах /уралдааны удирдамж боловсруулах/	11 дүгээр сар	5.000.000	Жендэрийн салбар хороо Сургагч багш нар
4	"Эрхэмсэг оршихуй" эмэгтэйчүүдийн сургалт	2 дугаар сар	500.000	Хууль эрх зүйн хэлтэс
Эрэгтэйчүүдийн клубүүдийн үйл ажиллагааг дэмжих				
5	"Гэр бүл ба Жендэр" сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	5-р сар	3.500.000	Хонгорын дугуйчид унадаг дугуйн холбоо Фото зургийн клуб
6	Залуучуудын морин аялал зохион байгуулах	6-р сар	1.500.000	БОАЖГазар
7	Өсвөр үед чиглэсэн сургалт зохион байгуулах	1-4 дүгээр улиралд	1.500.000	ЖҮХороо Сургагч багш
8	"Сайн аав" зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1-4 дүгээр улиралд	2.000.000	Нийгмийн бодлогын хэлтэс Цэргийн штаб
9	Видео, контент бэлтгэж хэвлэл мэдээлэл болон олон нийтэд түгээх	1-4 дүгээр улиралд	1.500.000	Нийгмийн бодлогын хэлтэс ГБХХГазар
Нийт			20.000.000	

oOo